



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 10 өдөр

Дугаар A/164

Цагаан-Уул сум

**Г Малын гоц халдварт шүлхий өвчний
дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Хөвсгөл аймгийн засаг даргын А/394 дугаар захирамжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын Шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/165 дугаар тушаалын хэргэжилтийг хангах хүрээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг сумын хэмжээнд бүх үхэр сүргийг хамруулан 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.
2. Дархлаажуулалтын арга хэмжээний ажлын хэсгийг шуурхай зохион байгуулан, өдөр тутмын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлэгийн тасгийн дарга, хяналтын улсын байцаагч (Т.Чандмаа)-д даалгасугай.
3. Дархлаажуулалтын арга хэмжээний үед шаардлагатай шатахуун, автомшинаар дэмжлэг үзүүлж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (У.Аварзэд)-д үүрэг болгосугай.
4. Дархлаажуулалтад хамрагдах малын тоог нэгдүгээр хавсралтаар, дээрх үйл ажиллагааг сумын хэмжээнд баг тус бүрээр зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
5. Дархлаажуулалтад шаардагдах вакциныг хуваарилан олгож, мэргэжил арга зүй удирдлагаар хангантайлан мэдээ, акт баримтыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлэн ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч (Т.Чандмаа) тархвар зүйч (М.Дуламжав) нарт үүрэг даалгасугай.
6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (У.Аварзэд)-д даалгасугай.

